



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Гэр хорооллын нөхцөлийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх явцад иргэдийг хохироосон тухай өргөдлийн дагуу хяналт шалгалт хийж, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Ж.Батзандан

-Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Д.Лүндээжанцан

-Улсын Их Хурлын гишүүн

Б.Болор

-Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Г.Нарантуяа

-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын  
Газрын харилцаа, геодези зураг зүйн  
хяналтын улсын байцаагч

Б.Энхмаа

-Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт  
Үнэлгээний хэлтсийн референт

Х.Баттөгсөх

-Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны  
референт

3. Тогтоолын дагуу холбогдох хянан шалгалтыг хийж, Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэг /Ж.Батзандан/-т даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Р.БУРМАА